



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 0190

Эг

Хорио цээрийн дэглэм цуцалж
хязгаарлалтын дэглэмд шилжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Хурх багийн нутаг Ханангийн жалга гэх газарт хаваржиж буй малчин Ц.Насанжаргалын хотонд гарсан хонины цэцэг өвчний шинж тэмдэг бүрэн арилж, вакцины дархлаа тогтох 14 хоног дууссан тул сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/75 тоот захирамжийг хүчингүй болгож 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс Хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс нутагт дахь мал сүрэгт үзлэг хийн, халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Ж.Ундрах)-д даалгасугай.

3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Эрсдлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Минжинсор)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНСҮХ

232401179